



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 01/182

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 6,591,000 /зургаан сая таван зуун ерэн нэгэн мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургууль /Л.Баянтуул/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургууль /Л.Баянтуул/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050000482

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны 05 дугаар сарын 06 -ны өдрийн  
0/182 дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургууль

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалта д авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Сурагчийн ширээ	ДСП хавтан	70x100x35	2019	сайн	ш	18	96,000.0	1,728,000.0	Баянзүрх Ротари клуб	Хандив
2	Сурагчийн сандал	ДСП хавтан	45x35x35	2019	сайн	ш	36	40,000.0	1,440,000.0		
3	Багшийн ширээ	Тумботой ДСП ширээ	70x120x70	2019	сайн	ш	1	398,000.0	398,000.0		
4	Багшийн хос ширээ	Хүрэн өнгөтэй ДСП хавтантай	70x100x110	2019	сайн	ш	1	850,000.0	850,000.0		
5	Багшийн сандал	Төмөр хөлтэй, торон	50x40x40	2019	сайн	ш	3	125,000.0	375,000.0		
6	Номын шүүгээ	Хүрэн өнгөтэй ДСП хавтантай	170x210x40	2019	сайн	ш	1	1,800,000.0	1,800,000.0		
<b>Тавилга, эд хогшлийн дүн</b>									<b>6,591,000.0</b>		